Fuji Today Newsletter

APR. 2021 | VOL12.

EDITOR-IN- CHIEF'S LETTER

I am thrilled to introduce our Fuji Today Online Newsletter. Our newsletter consists of three parts: Mongolian corner, English corner, and Japanese corner. Each corner has its unique and interesting articles. Considering that our school consists of bilingual students, everyone will understand and improve their language skills.

Consisting of 9 students, Japanese teacher and a Newsletter Advisor who had the same ambition, this newsletter absorbed a great amount of our hard work and effort.

By Bayasakh.G
Fuji Today Editor-in-Chief

ЭРЭЛХИЙЛ ЭРГЭЦҮҮЛ ДҮҮЛЭН НИС

QUEST

THINK

LEAP

We, the new Mongolians, state with pride and honor,
for generations ahead, the story of our school established as a fruit of generous
support and diligent efforts of Mongolian and Japanese, men and women.

Bearing in mind that generosity and gratitude, beget happiness, we will spread happiness and cherish our own.

Aspiring to be a globally valued Mongolian citizen, we will spare no efforts for personal growth, mobilizing our heart, mind, and body to the fullest.

Deeply respecting our fathers and forefathers, the authors of our proud history and our follow New Mongolians, the authors of our modern-day success, we will strive to build just, harmonious, and peace-loving Mongolia.

Fuji Today

newsletter team members

Reporter:
12-1 Khuslen. O

Editor-in-Chief
11-4 Bayasakh.G

Reporter:
11-3 Amar.Ya



Reporter:
11-3 Tsendari.J

Reporter:
9-1 Emujin.G

Reporter:
11-2 Maralgoo.G

Fuji Today

newsletter team members

Japanese section:
12-2 Khaliun.U

Japanese section:
12-1
Nomin-Erdene.B

Japanese section:
12-4 Ariunzaya.G

Newsletter Advisor
English Teacher
Khaliunaa.G

Japanese Advisor
Japanese Teacher
Uuriintuya.TS

Contents

Монгол булан

Мэдээ мэдээлэл- ***Энэ сарын онцлох мэдээ, Үнсгэлжин 2021-цахим уралдааны мэдээлэл***

Онцлох үйл явдал- ***Номын клуб***

Ярилцлагыг Г.Баясах

Онцлох багш- ***Бага ангийн НА Г.Ганчимэг***

Ярилцлагыг О.Хүслэн

Хуулийн булан- ***Хүүхдийн эрхийг хамгаалахад эцэг эх, асран хамгаалагч ямар үүрэгтэй вэ?***

Нийтлэлийг Г.Халиунаа

Тэтгэлэгт мэдээлэл- Канадын Ниагара коллеж

Нийтлэлийг Я. Амар

Кино булан- ***Waiting For Forever (2010)***

Нийтлэлийг Г.Баясах

СэтгэлЗүйн булан- Стресс гэж юу вэ?

Inside Out Psychological Club

English corner

Special student- ***Bolortuya.P (12-1)***

by Bayasakh. G

Self-help- ***Simple tips to have a glow-up***

by Emujin. G

Health corner- ***Countries with healthiest foods***

by Emujin. G

Creative corner- ***Making Chocolate chip cookie***

by Tsendari. J

Movie corner- ***Locke & Key***

by Maralgoo.G

Motivational Stories- ***A pound of butter "Honesty"***

by Maralgoo. G

Happy hour- ***Riddles***

日本のコーナー

アニメコーナー

ノミン·エルデネ

スペシャルゲスト

アリウンザヤ

ぜひ行ってみる場所!

ハリウン

Монгол Булан

Шинэ мэдээ, мэдээлэл

ЗОРИЛГО: Сургуулийн нийт сурагчдын гоо зүйн мэдлэг боловсрол болон бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тэдний бүтээлийг сурталчлахад чиглэгдэнэ.
ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: ШМХФ сургуулийн УГЗЗАН-ийн технологийн багш нар
ХУГАЦАА: 2021.04.15-05.10
ХАМРАХ ХҮРЭЭ: 6-12 ангийн нийт суралцагчид
ШАГНАЛ:

- Шилдэг дизайнеруудад БАТЛАМЖ хадгалуулан, сургуулийн **Fuji Today** сонинд нийтэлж онцлох, бэлтгэлийн хувцас хийлгэх эрх
- Сургуулийн шилдэгийн шилдэг брэнд загварыг үйлдвэрлэж, хэрэглээнд нэвтрүүлэх
- Шилдэг моделуудыг " Queen model agency"-т **50-100%** хөнгөлөлттэй сургалтанд сурах эрх, бүтээгдэхүүний нүүр царай болох эрхээр шагнаж урамшуулах
- Оролцсон оролцогч бүрт " Queen model agency"-т 10% хөнгөлөлттэй сургалтанд сурах эрх олгоно.

Холбогдох хаяг, утасны дугаар:
УГЗЗАН-ийн багш нарт тэмцээнд орох зураг материалаа анги нэрээ тодорхой бичин доорх мэйл хаягаар илгээнэ үү.
Д. Өнөболор утас: 99041677, email: d.unurbolor@shmhf.edu.mn /7,10,11-р ангиуд/
Р.Амгалан утас: 88052750, email: r.amgalan@shmhf.edu.mn /6,8,9,12-р ангиуд/

Энэ сард болсон онцлох үйл явдлууд

Англи хэлний заах аргын нэгдэл маань Америк багштай ярианы хичээлийг 6-11-р ангийн бүх түвшний сурагчдадаа зориулан 4 сарын 12-ноос эхлэн ярианы хичээл болон клуб хэлбэрээр явуулж эхэллээ.

2021-2022 оны хичээлийн жилийн 1-р ангийн элсэлтийн "Хамтарсан уулзалт ярилцлага " 4 сарын 3,4-ний өдөр амжилттай зохион байгуулж, эхний 72т орсон элсэгчдэд батламжийг нь гардуулжээ.

Байгалийн ухааны Заах аргын нэгдлийн 7 хоногийн арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал:

1. Сурагчдыг хөгжүүлэх
2. Багшийг хөгжүүлэх
3. Эрүүл аж төрөхүй
4. Таны мэдлэгийн санд гэсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд урам зориг эрч хүч өгсөн, ухаарал хайрласан онч мэргэн СУРГАМЖИТ ҮГСИЙН ХЭЛХЭЭСЭЭР багш сурагчдаа өглөө бүр урамшуулан, 6-р ангид химийн туршилт, 8-р ангид физикийн туршилт, 9-р ангид биологийн туршилт хичээлүүдийг маш сонирхолтой хэлбэрээр явуулаад зогсохгүй багш сурагчдад хандсан олон сонирхолтой ажлуудыг амжилттай зохион байгууллаа. Та бүхний цаашдын ажил хөдөлмөрт өндөр амжилт хүсье.

Элсэлтийн ерөнхий шалгалт-2021 оны шалгалтын тов батлагдлаа. ШМХФ сургуулийн нийт 12-р ангийн төгсөгчдөдөө шалгалтын бэлтгэлд нь амжилт хүсэж хүссэн оноогоо авахыг ерөөе!

TFB
Harumafuji
Book club

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Энэ удаагийн онцлох үйл явдал булангаараа та бүхэндээ Номын клубийг танилцуулж байна.

Энэхүү клуб нь одоогоор нийт 11 гишүүнтэй. Ном сонирхон уншдаг сурагчид номоос мэдэрсэн мэдрэмжээ хуваалцаж халуун дотно яриа өрнүүлэх орон зай болох, мэдээ мэдээлэл солилцох, номын ахан дүүстэй ном унших, номтой нөхөрлөхөд сэдэлжүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Ингээд та бүхнийг Номын клубийн ахлагч 11-4 ангийн сурагч Э.Амидатай уулзуулж байна.

Сайн байна уу? Бидний урилгыг хүлээн авсанд баярлалаа. Уншигч олондоо өөрийгөө танилцуулаач.

Сайн уу? Юуны өмнө "Harumafuji Book Club"-ийг маань энэ удаагийн дугаартаа онцолж байгаад Сонингийн клубийнхэндээ гүнээ талархъя. Намайг Э.Амида гэдэг. Би 11-4 ангид суралцдаг. Аливаад чин сэтгэлээсээ хандахыг эрмэлздэг.

Анх хэзээ байгуулагдсан бэ?

Анх МХБУЗ-ын Г.Нандин-Эрдэнэ багш маань "Номын клуб байгуулах гэж байгаа чи ахлагч нь болох уу?" гэж асуухад нь надад итгэл хүлээлгэн ийм гоё санал тавьсанд нь баярлаж, нөгөөтэйгөөр маш их хариуцлага гэдгийг ухамсарлаж клубээ 2021.02.22-ны өдөр нийгмийн ажилтан Насанбурмаа багшийн дэмжлэгтэйгээр Г.Нандин-Эрдэнэ багшаар удирдуулан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Танай клуб ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?

Цар тахлаас үүдэн одоогоор цахим хэлбэрээр клубийн гишүүд болон ахлах сургуулийн сурагчид руу гэсэн үндсэн 2 чиглэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Клубийн гишүүддээ: Номын хэлэлцүүлэг явуулах, зохиолчдын намтрыг судлах, номоос сэдэвлэн бүтээсэн кино жүжгийн талаар санал сэтгэгдлээ солилцох

Ахлах сургуулийн сурагчиддаа: Ном унших талаар сэдэлжүүлэх зорилгоор ном болон зохиолчдын мэдээллийг тогтмол бэлтгэн хүргэх, зохиолч орчуулагчдыг урьж халуун дотно яриа өрнүүлэх

Клубт элсэх шалгуур бий юу?

Ном унших дуртай, ном уншдаг болохыг чин сэтгэлээсээ хүсдэг хэн бүхэнд манай клубийн хаалга үргэлж нээлттэй шүү.

Төгсгөлд нь хэлэх зүйл байна уу?

Клубийнхээ гишүүдэд томоос том баярлалаа гэж хэлмээр байна. Мөн үргэлж зөвлөж, дэмжиж байдаг Нандиа багшдаа баярлалаа. Хамтдаа хичээж номд хайртай уншигч сурагчид болцгооё!

Клубийнх нь цааш цаашдын ажилд нь өндөр амжилтыг хүсье. Ярилцлага өгсөнд баярлалаа.

Ярилцлагыг Г.Баясах

ОНЦЛОХ БАГШ

Сайн байцгаана уу.
Уншигч та бүхэндээ энэхүү дугаараараа "Шинэ Монгол Харумафүжи" сургуулийн бага ангийн нийгмийн ажилтан Г.Ганчимэг багшийнхаа ярилцлагыг хүргэхээр бэлтгэлээ.

"Шинэ Монгол Харумафүжи" сургуулийн бага ангийн нийгмийн ажилтан Г.Ганчимэг

Товч танилцуулга:

2009-2012 он Өвөрхангай аймаг дахь цогцолбор сургуульд нийгмийн ажилтан
2012-2017 он Өвөрхангай аймаг дахь Гэрлэх ёслолын ордонд менежер
2017-2019 он Өвөрхангай аймгийн 10-р цэцэрлэгийн эрхлэгч
2019 оноос "Шинэ Монгол Харумафүжи" сургуулийн бага ангийн нийгмийн ажилтан

Таны бага нас хаана, хэрхэн өнгөрсөн бэ? Арван жилдээ ямархуу хүүхэд байснаасаа хуваалцаач.

Би Өвөрхангай аймгийн Хужирт суманд төрж, бага насаа төрөлх нутагтаа өнгөрүүлж, улмаар Хужирт сумынхаа 10 жилийн сургуулийг төгссөн.
Миний хувьд 10 жилийн сурагч байхдаа урлаг, спортын авъяастай, нийгмийн идэвх сайтай сурагч байлаа. 10 жилдээ сурсан эдгээр зүйлүүд маань одоо ч гэсэн ажил, амьдралд маань маш их хэрэг болдог юм.

Таны үндсэн мэргэжил юу вэ? Мэргэжлээ хэрхэн сонгосон бэ? Юу хамгийн их нөлөөлсөн гэж боддог вэ?

Намайг 10-р ангиа төгсөх тэр үед одоогийнх шиг мэргэжил сонголтын чиг баримжаа олгох, мэдээлэл өгөх үйл ажиллагаа огт байдаггүй байсан.
Тухайн үедээ өөрийнхөө дуртай, хамгийн сайн хичээл болох химийн хичээлээ суурь болгон сонгож, хими болон математикийн хичээлээр конкурс өгч ШУТИС-н “Хүнсний технологич-Эрүүл ахуйч” мэргэжлийг эзэмшсэн. Тус мэргэжлийг эзэмшин цаашид тогтвортой мэргэжлээрээ ажиллаагүй ч гэсэн миний хувьд энэ мэргэжил маань насан туршийн боловсролд маань үнэтэй хувь нэмэр оруулсан гэж боддог.
Миний хувьд инженерээс илүү нийгмийн оролцоотой байх, хүүхдүүдтэй ажиллах хүслээр жигүүрлэн дараах мэргэжлүүдийг эзэмшсэн.
2011 онд Энх-Орчлон дээд сургуулийг Багш, нийгмийн ажилтан, сэтгэл судлал
2014 онд Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулийг Боловсрол судлалын магистр
2018 онд Улаанбаатар Эрдэм Их сургуулийг СӨБ-ын багш, арга зүйч мэргэжлийг эзэмшсэн.

Оюутан насны амьдралыг хамгийн дурсамжтай цаг мөч гэж ярьдаг шүү дээ. Тэр үеийн сайхан мөчүүдээсээ хуваалцаач.

Хүүхэд насны балчир мөрөөдөлдөө эзэн суух, хүний амьдралын хамгийн хариуцлагатай хэрнээ, залуу насны зоримог шийдвэрээр цалгисан, хамгийн дэврүүн үе оюутан насанд л өнгөрдөг.
Би анх аав, ээжээсээ холдож 17 насандаа сумаасаа УБ хотод оюутан болж ирж байлаа. Тэр үед хамаатныхаа эгчийнд сууж, биеэ даан амьдрах хүндхэн үе тулгарсан. Аав, ээжээсээ холдож үзээгүй болохоор гэрээ маш их санадаг. Тэр үед гэрийнхэнтэйгээ ярих гэж одоогийн төв шуудан дээр оочерлон байж 2 минут ярьдаг. Аавынхаа дууг сонсоод уйлсаар байгаад олигтой ярьж чадалгүй минутаа дуусгадаг тохиолдол олон байлаа. Айлд суудаг болохоор айлынхаа цахилгааны мөнгийг хэмнэн оройн цагаар хичээлээ хийгээд сууж чаддаггүй тул сургуулийнхаа номын санд үдэш болтол сууна. Энэ үед л аав, ээжийнхээ дэргэд, гэрээсээ сургуульдаа явдаг хотын хүүхдүүд ямар сайхан бэ гэж битүүхэндээ атаархал төрдөг байлаа. Аав, ээжээсээ хол, тэднийгээ маш ихээр санан бэтгэрдэг хэдий ч сурч боловсрох хүсэл эрмэлзэл, аав ээжийн минь намайг боловсролтой хүн болгох гэсэн хичээл зүтгэлийг бодон өөрийгөө дайчлан амжилттай суралцаж чадсан юм. Энэ л үед би биеэ дааж, өөрийгөө дайчлан, хатуужил суусан хамгийн нандин үе минь байдаг.

"Шинэ Монгол Харүмафүжи" сургуульд ажиллах шийдвэрт тань юу хамгийн ихээр нөлөөлсөн бэ?

Миний хувьд Шинэ Монгол Харүмафүжи сургуулиа зорьж ирсэн байгаа. Сургуулийн маань "Дэлхийн боловсролыг эзэмших монгол иргэн, Дэлхийн дэвжээнд өрсөлдөх Монгол сургууль гэсэн алсын хараа нь энэ сайхан сургуульдаа ажиллах шийдвэрт хамгийн ихээр нөлөөлсөн.

Шинэ Монгол Харүмафүжи сургуульд ажиллахын давуу талаас дурдвал.

Би сургуулиараа, хамт олноороо, сурагчдаараа маш их бахархдаг. Сургуулийн маань соёл зөв төлөвшиж байгаа, сургуулийн удирдлагууд маань багш, ажилтнуудынхаа хөгжил, идэвх оролцоог маш сайн дэмждэг, ажиллахад урам зориг нэмсэн маш сайхан баг, хамт олон бүрэлдсэн гэх мэт давуу талууд олонтой. Сургуулийнхаа соёлыг бэхжүүлэхийн төлөө хамт олныхоо нэг эд эс нь болон ажиллаж байгаадаа миний хувьд маш их баяртай байдаг.

Саяхан шинэ хичээлийн жилийн нэгдүгээр ангийн элсэлт явагдсан шүү дээ. Элсэлтийн зохион байгуулалт хэрхэн явагдсан болон шалгуур үзүүлэлт, журмын талаар мэдээлэл өгөөч.

Бид COVID-19-н нөхцөл байдлын улмаас 2021-2022 оны хичээлийн жилд 1-р ангийн элсэлтийг эцэг эх, хүүхэд, сургуулийн “Хамтарсан уулзалт” ярилцлага хэлбэрээр 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр цахимаар амжилттай зохион байгуулсан. Энэ удаагийн “Хамтарсан уулзалт” ярилцлагад 540 гаруй хүүхэд оролцсон байгаа.

Бага анги тэр тусмаа нэгдүгээр ангийн бяцхан хүүхдүүдтэй ажиллаж, чиглүүлнэ гэдэг хамгийн чухал ажил шүү дээ. Тэдгээр хүүхдүүдтэй ажиллахдаа юуг анхаарч, юуг зарчим болгодог вэ?

Өдөр бүр сургуулийнхаа бяцхан сурагчдаасаа оргилсон их эрч хүч, бялхам их энергийг авдаг. Хүүхэд бүр өөр өөрийн гэсэн онцлог, давуу талтай. Тиймээс хүүхэд бүрийн сонирхол, онцлогт тулгуурлан сурагчидтайгаа харилцах, ажиллах, цаашлаад хүүхэд бүр өөрөө өөрийнхөөрөө хөгжих, бие даан суралцах чадварыг нээн хөгжүүлэх нь хамгийн чухал гэсэн зарчмыг баримтлан ажиллаж байна. Сургуулийн бага нас гэдэг хамгийн чухал үе.

Та хувь хүнийхээ хувьд баримталдаг амьдралын зарчим, гол чиг шугамаасаа бидэнтэй хуваалцаач.

Намайг бага байхаас минь л аав, ээж 2 минь аливаад ***“ҮНЭНЧ”*** байх гэдэг зүйлийг захиж, үлгэрлэж сургасан. Одоог хүртэл өөртөө болон бусдад үнэнч байх, хариуцсан ажилдаа үнэнч байх, шударга байх зарчмыг баримталдаг.

Та чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг вэ?

Миний хувьд амралтын өдрүүдэд ихэвчлэн хувь хүний хөгжилд чиглэсэн ном уншиж өнгөрүүлдэг. Аливаа шинэлэг зүйлийг мэдэж, сурахыг эрмэлздэг.

Өөрийн хамгийн том давуу тал гэж боддог 3 зүйлийг бидэнтэй хуваалцвал юуг нэрлэх вэ?

- Зохион байгуулалттай
- Санаачлагатай, бүтээлч
- Аливаад уян хатан ханддаг

Төгсгөлд нь бидний ярилцлагыг уншин суугаа уншигчдадаа хандан үг хэлээч.

Дугаартаа урьж, сонирхолтой ярилцлага өрнүүлсэнд маш их баярлалаа.
Хүний хамгийн гол өрсөлдөгч бол танд оногдсон цаг хугацаа байдаг. Тийм болохоор урсан өнгөрч буй цаг хугацаанаас өрсөж, түүнтэй уралдан зөвхөн зорилгынхоо төлөө тууштай зүтгэж ихийг бүтээхийг та бүхэндээ хүсэн ерөөе.

Маш их баярлалаа. Сайхан ярилцлагыг уншигчдадаа хүргэсэн танд ч бас их талархлаа. Танд ажлын арвин их амжилтыг хүсэн ерөөе.

Сайхан бүхэн уншигч тантай хамт байг.

Ярилцлагыг О.Хүслэн

NIAGARA COLLEGE CANADA

/ КАНАД УЛСЫН НИАГАРА КОЛЛЕЖ

Ниагара коллеж нь 1967 онд байгуулагдсан бөгөөд Канад улсдаа 3, олон улсад нийт 6 кампустай №1 судалгааны коллеж юм. **15000** гаруй бүтэн цагийн оюутан суралцагчид **130** гаруй мэргэжлээр **Бакалавр, Магистрын зэргээр** суралцаж байна. **Ниагара Коллеж** нь 5 хоногийн турш албан ёсоор онлайнаар танилцуулгаа хийж байгаа тул уншигч сурагчдаа оролцохыг урьж байна.

2021.4.13-4.17 хооронд явагдах ба
Онлайн танилцуулга уулзалт 4 хэсэгтэй:
1-Сургалтын хөтөлбөр
2-Элсэлт
3-Төлбөр
4-Карьер

Бүртгэл:
http://www.nogoonjade.mn/nogoon-jade-event-lp/

Хүүхдийн эрхийг хамгаалахад эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ямар үүрэгтэй вэ?

Цуврал 2

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуульд заасанчлан Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчныг бүрдүүлэх;
- Хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх;
- Хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах;
- Хүүхдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмших, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах;
- Хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах;
- Хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хадгалж, хувийн орон зайг хамгаалах;
- Хүүхдийг хүндэтгэн сонсож, шийдвэр гаргах;
- Хүүхдийг хөгжиж, төлөвшихөд нь дэмжин туслах;
- Хууль тогтоомжид заасны дагуу хүүхдийнхээ өмнөөс хариуцлага хүлээх;
- Хүүхдийг наад захын хэрэгцээт зүйлээр хангах болон хууль тогтоомжид заасан бусад үүргийг хүлээнэ.
- Эцэг, эх нь тусдаа амьдрах, гэрлэлтээ цуцлуулсан нь тэднийг энэ зүйлийн эдгээр үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авна.

- Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсөж хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, шаардлага, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж, түүнийг шийдвэрлүүлэх замаар хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- Гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу үзүүлнэ.Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.
- Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчин өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхгүйц тоглоом мэдээ,мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална.

"Waiting For Forever" (2010)



Waiting for Forever буюу "Үүрд хүлээнэ" кино нь Жеймс Кичийн найруулсан, Рейчел Билсон болон Том Старриж нарын тоглосон Америкийн романтик кино юм. 2011 оны 2-р сарын 4-ний өдрөөс эхлэн кино театруудын дэлгэцнээ гарч эхэлсэн энэхүү киног Солт Лейк Сити мөн Юта мужийн Огден хотод зураг авалтыг нь хийжээ.

IMDb 6/10

~Тэрээр түүнээс "Чи намайг дагаад байгаа юм уу?" гэж асуугаад тэд тэврэлдэн инээлдэв.

Уилл Доннер бол 10 настайдаа эцэг эхээ алдаж гүн цочролд орон сэтгэцийн өөрчлөлттэй болсон гудамжны уран бүтээлч юм. Түүнийг эцэг эхээ алдсан хэцүү үед нь Эмма үргэлж дэргэд нь байж сэтгэл санаагаар дэмждэг байв. Уилл Эмма-д их сайн түүнд маш их хайртай. Үүнээс хойш тэд холбоо тасарсан бөгөөд олон жилийн дараа Уилл төрөлх газраа зорин ирнэ. Энэ үед Эмма ч мөн аавыгаа өвдсөн гэх мэдээгээр буцаж ирэхээр болов. Уилл Эмма-д хайртай гэдгээ хэлэхээр шийдсэн боловч тийм ч амар биш байлаа. Учир нь Эмма найз залуутай болсон байх ба Уилл зориг гаргаж чаддаггүй. Нэг удаа Уилл Эммагийн гэрийн гадаа зорьж очоод, Эмматай уулздаг. Тэд өнгөрсөн сайхан дурсамжуудаа дурсаж хамтдаа цагийг өнгөрүүлдэг. Гэтэл Эммагийн найз залуу түүнтэй эвлэрэхээр тус хотод мөн ирсэн байлаа. Ингээд энэхүү адармаатай хайрын түүх хэрхэн үргэлжлэхийг киноносоо хүлээн авч үзээрэй. Уилл хайртай гэдгээ хэлж чадах болов уу? Эмма түүнийг яаж хүлээж авах бол?

Нийтлэлийг Г.Баясах

Сэтгэлзүйн булан
Inside Out Psychological Club



Стресс гэдэг ойлготыг анх Канадын эрдэмтэн Г.Селье гаргаж иржээ. Энэ үгний утга нь хүчээр үйлчлэх, доргиох, хүч үзүүлэх гэсэн утгатай. Цаашлаад “Хүнд гаднаас үйлчилж буй эерэг сөрөг хүчин зүйлийн үйлчлэл, түүнд организмаас хариу өгөх чадвар түүнтэй дасан зохицох чадварыг стресс гэнэ. Стрессийг илэрч буй нөлөөллөөр эерэг /эустресс/ сөрөг /дистресс/ гэж 2 хуваана. Стресст өртсөн хүнд олон шинж тэмдэг илэрдэг.

Жишээлбэл, нойргүйдэх, амархан сэрэх, анхаарал төвлөрөхгүй байх, булчин чилж өвдөх, хоолны дуршил багасах, байнга ядарсан мэдрэмж төрөх, жижиг зүйлст хэт сүртэй сэтгэл хөдлөл үзүүлэх, шалтгаан тодорхойгүй түгшсэн мэдрэмж төрөх, байнга уурлах гэх мэт олон сөрөг нөлөөллийг биемахбодид болон сэтгэлзүйд үзүүлж байдаг. ***Тэгвэл өсвөр насны хүүхдүүдэд стресс үүсгэдэг нийтлэг асуудлыг дурьдвал:***

- Гэрийн даалгаварын ачаалал, (ялангуяа шалгалт дөхсөн үед ихээр мэдрэгддэг)
- Эцэг эх, гэр бүлийнхнээс үзүүлдэг олон янзын хүлээлт, шаардлага,
- Гэр бүлийн харилцааны таагүй сөрөг байдал
- Найз нөхдийн харилцааны асуудал, найз нөхөдгүй байх
- Үерхэл нөхөрлөлийн харилцааны асуудал
- Мэргэжил сонголтын эргэлзээтэй байдал
- Нойрны дутагдал гэх мэт асуудлууд түгээмэл тулгамддаг байна.

Өсвөр насны хүүхдүүдийн хувьд өөрт тулгамдсан асуудлаа хүндрүүлэн бодох, хэтрүүлэн хүлээж авах хандлагатай байдаг бөгөөд энэ нь тэдний сэтгэлзүйн онцлогтой холбоотой байдаг. Тийм ч учраас өөрт тулгамдсан асуудлаа шийдвэрлэхдээ илүү сэтгэл хөдлөлөөр хандах, эсвэл шийдвэрлэж чадахгүй удаан хугацаанд стресстэж явах нь элбэг тохиолддог. Түүнээс гадна стресст өртөх магадлал өндөр хүмүүс гэж байдаг. Биологийн хэв шинж талаас нь аваад үзэх юм бол гол төлөв дуу султай, амьдралын идэвхи багатай, гутранги үзэлтэй хүмүүс стресст өртөх магадлал өндөр байдаг. Мөн эсрэгээрээ огцом, түрэмгий зан авиртай хүмүүс бусдаас илүү их стресст өртдөг. Харин сэтгэцийн хэв шинжээр авч үзэх юм бол хэт мэдрэмтгий, санаа зовомтгой, сэжигч, аливаад чин сэтгэлээсээ ханддаг, ажил хийвэл дуустал хийдэг, юмны нарийн учрыг нь олох гэж хичээдэг хүмүүс стресстэх магадлал өндөр байдаг.

Стресс тайлах оновчтой аргуудыг та бүхэнтэй хуваалцая:

- Өдөр тутамд хийж байгаа зүйлээ төлөвлөж, зөв хуваарил - Ажлаа өдөр, долоо хоног, сар, улирал, жилээр төлөвлө. Төлөвлөгөөнд ороогүй бөгөөд шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд хүнд “үгүй” гэж хэлж сур.
- Инээмсэглэ - Сайхан инээмсэглэл сэтгэл сэргээгч эм юм.
- Уур бухимдлаа тайлах арга – Уурлаж стресстсэн үедээ тогтмол хийдэг зүйлтэй болох хэрэгтэй. Юу хийвэл амархан тайвширч байгаагаа олж мэдээрэй.
- Өөрийнхөө тухай сайн сайхнаар төсөөлөн бодох – Өөрийгөө магтаж урамшуулж хайрлаж байх
- Сөрөг бодол мэдрэмж өгдөг зүйлсээс хол байх – магадгүй уулзахаар эсвэл харилцахаар хэцүү байдаг, таагүй санагддаг хүнээс хол байх нь ч тустай.
- Сөрөг бодол мэдрэмжээ эерэг болгон бичих – мэдрэмжээ таних, гадагшуулах нь хамгийн сайнаар тайвшрах арга, мөн эерэг хандлагад төлөвшүүлж байдаг.
- Бусадтай ярилцах - Өөрт тулгамдсан асуудлууд, үүсч байгаа тааламжгүй мэдрэмж, тааламжгүй бодлоо найз нөхөддөө, гэр бүлийнхэндээ, эмч болон бусад ойр дотнын хүмүүст илэн далангүй илэрхийлэх ярих. Бүр өөрөө өөртэйгээ ярих ч үр дүнтэй байдаг.
- Өөрчлөлт, шинэчлэлт стресс тайлах эм - Нэгэн хэвийн байдлаас салж өөрчлөлт хийх хэрэгтэй. Үсээ тайруулах, хичээлийн ширээн дээрх зүйлсээ байрлалыг нь өөрчлөх цэгцлэх, солих, шинэ зүйл худалдаж авах гэх мэтээр сэтгэлзүйдээ шинэ зүйлийг мэдрүүлж байх хэрэгтэй. Өнгө хүртэл сэтгэлзүйд нөлөөлж байдаг.
- Өөрийгөө баярлуулах - Амрах, найзуудтайгаа утсаар ярих, дуу сонсох, салхинд алхах гэх мэтээр өөрийнхөө дуртай зүйлийг хийх хэрэгтэй. Ямар зүйлээс хамгийн их сэтгэл ханамж авдаг гэдгээ бодоод түүнийгээ хийгээд үзээрэй.
- Дасгал хөдөлгөөн хамгийн чухал эм - Хаана ч байсан хийх боломжтой, бас хамгийн хурдан тайвшрах арга бол амьсгалын дасгал юм. Амьсгалаа гүнзгий хүчтэй аваад гаргах. Гурван секунд амьсгаагаа гүнзгий аваад, гурван секунд түгжээд, гурван секунд буцаагаад гаргах дасгалыг хийгээд үзээрэй. Дасгалыг хийх явцдаа цээж дүүрэн амьсгалж, гаргахдаа бүх амьсгаагаа гаргах хэрэгтэй. Энэ дасгалын үр дүнг маш олон хүн мэдэрсэн байдаг шалгарсан арга шүү хүүхдүүдээ. Мөн булчингаа ажлуулсан дасгал хийх нь үр дүнтэй байдаг.

Уншигч та бүхэн стресст өртсөн үедээ дээрх аргаас өөрт тохирсон аргаа олоод хэрэгжүүлээд, стресстэхгүй эерэг хандлагатай байж, өдөр бүр аз жаргалтай амьдрахад төвлөрцгөөе гэж уриалж байна.

English Corner

SPECIAL STUDENT

Bolortuya Purevtseren

BE KIND, FOR EVERYONE YOU MEET IS FIGHTING A HARD BATTLE. -PLATO

Thank you for accepting our invitation. Please give us a brief introduction about yourself to our readers?

Peace be upon everyone who reads the Fuji Today. First of all, thank you for inviting me! My name is Bolortuya Purevtseren, 12-1 grade student.

Congratulations on your scholarship from Russia. How did you find out about the scholarship?

Thank you very much. I only know from my two old high school sisters that they were on this scholarship. Detailed information was first obtained from the РЦНК website.

Please tell us about your scholarship and how you prepared.

The Russian government provides about 56 million MNT for the scholarship.

Scholarships vary depending on the school you attend. You will have to pay for your own accommodation and travel expenses. This scholarship, known to many as Putin's, is probably the main goal of Russian school students. For this year, because of COVID, the portfolio is balanced based on essays, achievements, grades, and the submitted application.

I think all the things I've learned in 12 years and taken the initiative in the past were my preparation.

Because I wrote everything I had in 3 days and sent everything on time. I concluded that this scholarship is the result of my family and my 12 years of hard work.

People often choose countries such as the United States, Canada, and Japan. Why did you choose Russia?

From kindergarten to 5th grade, I attended a Russian school called Raduga-"Rainbow". Almost every day I memorized poems and traveled through the history and culture of Russia. That's why I love Russia so much. As for me, I did not choose Russia, so I sent this scholarship application from the perspective of why it should not be. I have heard that the Russian education system is strict, and it is more difficult to study in my chosen profession to graduate from an ordinary university in any country. But it is a wonderful challenge for me since I loved it so much.

Have you ever been to Russia? What do you like most about Russia?

I have been to Russia once in my life. I had a chance to go there.

In middle school, I went to Ulan-Ude on an exchange program. Everything is beautiful, but Russian history, traditions and literature are the most fascinating.

How and why did you first decide to enroll in the New Mongol Harumafuji School?

I took the entrance exam for the 6th grade at the New Mongol school but I couldn't pass. For some reason, the uniforms and the New Mongol school seemed very nice to me. Then one day I was walking to school in the same uniform, and my dream had come true. I think I was destined to study at a New Mongol Harumafuji.

What is one of the best things about our school?

Atmosphere. When the atmosphere is good, everything is successful and any place is filled with light from inside. Our school atmosphere is created by all the students in the school, the teachers, the brothers who greet us with a smile when we come in the morning, the morning radio songs...etc. By the way, I miss my school a lot.

If not a secret, what is your biggest goal?

My goal is to find a way out for someone who is having a hard time or asking for help, to help someone who is most needed through profession, and to try to work in every field of my profession. More specifically, I want to be a public defender and help people for a while. A public defender is an attorney-at-law appointed by the courts and provided by the state or federal governments to represent and advise those who cannot afford to hire a private attorney. But the biggest goal, as my friend Zoloo says, is to be busy and successful, but don't forget to live. This is not only my goal, but also something that I think other people should remember.

Are there any plans for this summer?

Sure. After completing the Entrance Exam, I will take a driving course, prepare for exams, and travel alone with my family before my busy university life.

Describe yourself in three words.

Generous, Creative, Loving.

What do you most want to do in the future?

Let me tell you about a dream I think about more than my biggest goal. If you've seen "Into The Wild", I would love to travel like the main character in the movie. I secretly dream of making a travel diary and turning it into a book.

Where do you want to travel?

In 2017, while traveling to the United States, I met a Turkish girl. My first international friend. During this quarantine, I watched a Turkish movie with my family. I want to travel to Turkey to meet my friends because I like about culture, people and history of Turkey.

What do you do in your free time?

I like to write. I like to connect lines and write down my feelings. I want to write good text, so I need to read well. That's why I like reading. Occasionally there are bookmarks for drawing. Later I learned something called "Lettering".

Recommended movie or song?

Billy Joel-Vienna Listen to this song with your eyes closed or as you walk through the city. Lost in Translation - Just watch this movie.

Finally, do you have anything to say to our readers?

I am the sum of all these 17 years and so many people who have met me, loved me, believed in me and taught me. I thank to my friends who support me, teacher Undarmaa, the sisters who trust me, and my most precious family. To the readers, your dreams will come true. Think and dream of wonderful things and you are driven by it!

by Bayasakh. G

SELF CARE

SIMPLE TIPS TO HAVE A GLOW UP

Caring & Loving urself is the best love u can ever offer to someone

1. Drink water early in the morning

It's very important to drink water first thing in the morning because water raises our level of awareness and helps our brain to start a new day freshly! It also dilutes the acidity of stomach, making it more comfortable to eat afterwards. So enjoy your breakfast after few glasses of pure water...

2. Do a small and simple exercises everyday

If you want to keep your body in good shape, of course, exercises are must! But to do that, there's no need for any type of equipments, gym classes or even intense exercises! All you need is some simple movements and keep that up everyday, don't slack up! Even walking outside, in the fresh air for at least few minutes a day can improve your health better than any other intense exercises or expensive gym classes.

3. Eat on time

Instead of skipping meals to diet, it's somehow better to eat what you wanna eat but just on time! In fact researchers say that if you skip your breakfast, you will more likely to gain even more weight as your metabolism rate will go down, causing the food to be stored as a fat instead of being used as an energy.

4. Avoid late night snacks

Seriously, one of the thing that damages our health the most is "LATE NIGHT SNACKING". Most people are aware of this, but still we certainly give up and eat before going to bed sometimes. And you should stop that, because the foods we eat after 7pm till next morning, will become nothing more than just an extra fat. But if you do really crave for sth to eat, foods like fruit, hummus, yoghurt and dark chocolate are optional choices.

5. Take care of your skin.

As we all know, having a smooth and silky skin is one of the biggest beauty standards out there. Firstly, you should avoid applying heavy makeup, and not to use many different types of beauty products as well, because they are more likely to end up damaging your skin layers. Secondly, the simplest way to take care of your skin is to wash your face in the morning and before going to bed with pure water and face cleanser (that is suited with your skin type) if necessary. Tap, tap, tap and dry with towels. Sleep also affects the skin health so make sure to get enough sleep at night. You may also use face scrub but don't scrub your poor skin too hard, cuz u are gonna end up harming your skin. And also just leave your pimples alone. They will be gone on their own once ur puberty ends. Acne is a normal part of teenager life so there's no need to rush or hide the process that much,. Popping them might even worsen it. If really necessary seek dermatologist.



6.Last but not least your emotions

Becoming prettier or manlier is not all about fitting in the beauty standards, it is more about learning to love yourself. There are various type of ways for you to feel more proud and confident in your appearance, and some of them are just so simple and you may haven't realized it before. Just like changing your make up style a bit, or getting a different haircut, maybe even changing what you usually wear can make you totally different and more beautiful

by Emujin. G

COUNTRIES WITH HEALTHIEST FOODS

"Greece"

Greek cuisine is part of the culture of Greece and is recorded in images and texts from ancient times. Its influence spread to Rome and then throughout Europe and even beyond that. It's also considered as the healthiest cuisine around the world, because it contains much of olive oil, fish, lean meats, vegetables, herbs and grain etc... That's the reason why they are called heart healthy foods. Olive oil is the basic ingredient that most Greek cuisine include, and it's must. Some Greek cuisines are also rich in seasonings, and uses variety types of vegetables and fruits. "Pita" is very popular dish in Greek, just like how pizza is popular in Italy, it's really wildly spread. It is kind of similar to pie and there are various types of pitas, such as "Tiropita" which is traditional Greek cheese pie. Yummy!

PITA BREAD

Paella

Gazpacho

Ensaladilla Rusa

"Spain"

As healthy but delicious with many flavors and different seasonings, what else other than Spanish Traditional cuisines could be more suitable for a diet when you got both appetite, but also some will to lose weight. Spanish cuisines are part of the Mediterranean diet foods. Mediterranean diet are diets based on food from Mediterranean countries and is recommended as one of the healthiest diet. By eating meals with lots of vegetables, fruits, whole grains, beans, nut and seeds, and olive oil, you can reduce the risk of developing heart disease or cancer, and also the chances of dying at any age by 20%. Some of the popular Spanish cuisines that you should definitely try..."Paella" (a rice dish made by many different ways and ingerdients), "Ensaladilla Rusa" (the local name for the Olivier salad), "Gazpacho" (a vegetable cold soup) and "Tortilla de Patatas" (Spanish omelette).

"Japan"

Japanese is well known for their technology, food and culture. From the cuisines around the world Japanese meals are considered as one of the healthiest ones. The traditional cuisine of Japan "Washoku (和食)" is based on rice with miso soup and other side dishes of fish, pickled vegetables, and vegetables cooked in broth. They mostly eat seafood, prepared by various types of ways like roasted, fried and even raw as sashimi or in sushi. Japan is also popular with their rice growing and harvesting. Japanese snacks are wonderful too and not to mention their traditional green tea, which has a beautiful green color and scent. But they can be a bit bitter, so to milder the taste they drink it with "Wagahshi (和菓子)", one type sweets.Green tea is also good for health, such as it helps the brain functioning, burns extra fat and said to be anti-aging etc... Japanese cuisines are delicious and colorful and absolutely stunning! Plus they are healthy, that one of the secrets Japanese people age long and well are related to their foods and also how they eat.

(和食)

刺身, Sashimi

みそ Miso

鮨飯 Sushi

ご飯 Gohan

塩鮭 Shiozake

天ぷら Tempura

お茶 Ochya

Japanese bakeries

和菓子 Wagashi

by Emujin. G

Chocolate chip cookie

Chocolate chip cookies are one of my favorite things in the whole world. So much so that I consider them my comfort food. Whenever I'm feeling sad, bored or hungry I always bake them. I bake them for my friends and I bake them for my family and most importantly make them for me. And it's super simple to make too. Here is what you need.

1 cup butter, softened

1 cup white sugar

1 cup packed brown sugar

2 cups semisweet chocolate chunks

2 teaspoons vanilla extract

1 teaspoon baking soda

½ teaspoon salt

3 cups all-purpose flour

2 eggs

1. In a large bowl whisk together the sugar, salt and butter until it forms a paste.
2. Whisk in the egg and vanilla until light ribbons fall off from the whisk and remain for a short while.
3. Sift the flour and baking soda and gently fold them and use a spatula. be careful not to over stir them.
4. Fold in the chocolate chunks and let them rest for at least 30 minutes.
5. Preheat the oven to 180 degrees and line them up with parchment paper.
6. Scoop did though out of the bowl into the parchment paper at least 10 cm away from each other.
7. baked in 10 to 15 minutes until the edges barely brown. Cool them completely and enjoy!

by Tsendari. J

Locke & Key (2020)



Meredith Averill

American television writer and producer. Born in Pottsville, Pennsylvania, Averill graduated from New York University with a degree in screenwriting.

Locke & Key (2020) is an American supernatural horror drama streaming television series developed by Carlton Cuse, Meredith Averill, and Aron Eli Coleite, based on the comic-book series of the same name by Joe Hill and Gabriel Rodríguez. It premiered on Netflix on February 7, 2020.

After their father is murdered under mysterious circumstances, the three Locke siblings and their mother move into their ancestral home, Keyhouse, which they discover is full of magical keys that may be connected to their father's death. As the Locke children explore the different keys and their unique powers, a mysterious demon awakens - and will stop at nothing to steal them. From Carlton Cuse and Meredith Averill, Locke and Key is a coming-of-age mystery about love, loss, and the unshakable bonds that define family.



By Maralgoo. G

A pound of butter (Honesty)

There was a farmer who sold a pound of butter to a baker. One day the baker decided to weigh the butter to see if he was getting the right amount, which he wasn't. Angry about this, he took the farmer to court.

The judge asked the farmer if he was using any measure to weight the butter. The farmer replied, "Honor, I am primitive. I don't have a proper measure, but I do have a scale."

The judge asked, "Then how do you weigh the butter?"

The farmer replied:

"Your Honor, long before the baker started buying butter from me, I have been buying a pound loaf of bread from him. Every day when the baker brings the bread, I put it on the scale and give him the same weight in butter. If anyone is to be blamed, it is the baker."

Moral of the story:
In life, you get what you give. Don't try and cheat others.

By Maralgoo. G

Happy Hour Riddles

B. If you drop me I'm sure to crack, but give me a smile and I'll always smile back. What am I?

A. What common English verb becomes its own past tense by rearranging its letters?

D. A man calls his dog from the opposite side of the river. The dog crosses the river without getting wet, and without using a bridge or boat. How?

C. I have lakes with no water, mountains with no stone and cities with no buildings. What am I?

E

Can you write down eight eights so that they add up to one thousand?

F

What goes through cities and fields, but never moves?

Issue 5 answer

Math riddle answer: I am 40 and my daughter is 10.

IQ question answers:

1. C
2. A
3. C

We are happy to announce that the 6-3 class student Maraljin.T was the first student who sent us the correct answer to issue 5. Thank you so much. We wish you the best!

日本のコーナー

アニメコーナー

今回私たちがお勧めしているアニメのテーマは「親子」であり、家族と一緒に見える可愛いアニメです！どうぞ楽しみしてください。

名前：おおかみこどもの雨と雪(wolf children)

制作会社：スタジオ地図

上映時間:117分

公開:2012年7月21日

興行収入:42.2億円

すじがき

真面目な大学生のハナは、実は学生ではないが、クラスに通う謎の男に恋をする。 でも、彼は人間ではありません。 満月の夜、彼は変身し、彼が生きている最後の狼男であることを明らかにします。 それにもかかわらず、ハナの愛は強いままであり、2人は最終的に家族を始めることにしました。
二人は、降雨時に生まれたアメと降雪時に生まれたユキの2人の健康な子供を産みます。どちらも父親から受け継いだ、オオカミに変身する能力を持っています。 しかし、突然夫が亡くなり、ハナは自分で野生の子供たちを育つことになります。 「おおかみこども」は、容赦のない現代の世界でシングルマザーになるという課題についての心温まる物語です。

スペシャルゲスト

SPECIAL GUEST

**みなさんこんにちは、
今日のスペシャルゲストは
アリウンバヤルさんです。**

**こんにちはアリウンバヤルさん、まずは、
自己紹介おねがいします。**

こんにちは。新モンゴル日馬富士学園高等部二年一組アリウンバヤルです。本日は、ご招待ありがとうございました。できる限りのことは答えていきますので、どうぞよろしくお願いします。

日本では、どこに住んでいましたか？あと、いつ行って何年いたかもお願いします。

僕はちょっど小学校を卒業してから日本へ行って、中学校をそこで卒業しました。合計四年間ですね。石川って県の金沢市という所に住んでいました。とてもいい所です。ぜひおすすめです。

日本に着いて、真っ先に思ったことは何でしたか

そうですね。一番先に思ったのは、すんごい暑かったです。なんか湿度が高いからなのか、息しにくかったです。まあ、だんだん慣れていったけど。

日本とモンゴルの違いを一つあげてください？

やっぱ、一番大きな違いは礼儀だと思います。人に迷惑をかけないとする心と人に対する謝罪と感謝の気持ちが物凄いです。是非そういう所を取り入れ出来たらなって思います。

一番好きだったのは、なんの授業でしたか

以外のことに国語の授業が好きでしたね笑。先生も面白い人だったのもあるけど、やっぱダントツです。それから、社会科と体育ですね笑。体育は欠かせません！

日本鑑定試験受けたと聞きましたが、今は何級をお持ちですか？

今はN1ですね。まあ、合格できてよかったです、本当に(-。-)

日本にいた時に起きた面白いエピソードがあったらどうぞ。

国語の先生がめっちゃ面白い人だったんだけど、ある日お弁当忘れて来た子がいて、それを先生に報告した所、先生が「そっか、隣の奴に見せてもらえ」って言った時のことが頭から離れません笑。

最後に感想を一言お願いします。

最初にも言いましたが、今日はありがとうございました。招待していただき光栄です。自分のことを話すと、僕はまた日本へ行きたいと思っています。それが今の僕の目標です。目標に向けて毎日地道に頑張っている日々です。皆さんもに、何らかの目標があることでしょう。是非、達成できるように頑張ってほしいと思います。ご拝読ありがとうございました。

インタビューに答えていただきありがとうございます。

インタービュー:
アリウンザヤ

ぜひ行ってみる場所!

なばなの里の圧倒的なスケールとイルミネーションの美しさは、世界中から多くの人々を集中してしています。

公園は混雑が少なく、降雨はイルミネーションを反映し、きらめきを倍増させるので、雨の日をお勧めします。

皆ぜひ行ってください。

日本最大のイルミネーション



桑名

午前10時～午後10時

Thank you for being with us
Please continuously
support us reading our newsletter

Fuji Today сонинд нэгдэхийг хүсвэл:

Хэрвээ та манай баг хамт олонтой нэгдэж хамтарч ажиллахыг хүсвэл доорх хаяг руу бичээрэй

g.bayasakh_2@shmhf.edu.mn

Joining Fuji Today

If you want to be a part of our team, just send an email with a brief explanation to

g.bayasakh_2@shmhf.edu.mn

[Fuji today] 新聞に参加したい人いる場合、このメイルに書いてください。

bat.nominerdene_1@shmhf.edu.mn